



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



From
the People of Japan



Save the Children

“ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ-2” ТӨСӨЛ (2021-2024)

МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС № 9

2024 оны 3-р сар

Төслийн эцсийн үнэлгээний товч үр дүн



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1.

Тусгай хэрэгцээтэй хүүхдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл сайн хангагдсан байна.



Бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн **63.3 хувь**, багш нарын **85.1 хувь**, эцэг эхийн **80.5 хувь** нь тусгай хэрэгцээтэй хүүхдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцахад бэлтгэл сайн хангагдсан гэж үзжээ.

ЗОРИЛОТ СУРГУУЛИЙН ХҮҮХДҮҮДЭД ДАРААХ ӨӨРЧЛӨЛТҮҮД ГАРЧЭЭ:



Тусгай хэрэгцээтэй хүүхдийн тухай ойлголт, мэдлэгтэй болж тэдний сурч хөгжих онцлогийн талаар мэдэж авсан.




Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй харилцах, ярилцах болж тэднийг ойлгож, хүлээн зөвшөөрөх, эергээр хандаж дэмжих болсон.



Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, хамгаалах, шийдвэр гаргахдаа өөрийнхөө оронд тавьж боддог болсон.



"Хамтдаа дэвшин суралцъя-бага ангийн сурагчдын танилцах аялал"
39-р сургууль, 2023.12.14



"Бага ангийн сурагчдыг хэрхэн дэмжих вэ?"
СӨУЗ-ийн сургалт,
49-р сургууль, 2023.11.01

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2.

Суурь боловсролын түвшинд тусгай хэрэгцээтэй хүүхдийг хүлээж авах, дунд ангид суралцах орчинд дасан зохицох үйл явцыг нь дэмжих багшийн ойлголт, мэдлэг, ур чадвар, оролцоо, сургуулийн санал санаачилга сайжирсан байна.



Зорилтот сургуулийн дунд ангийн багш нарын **98,6 хувь** нь Тэгш хамруулах боловсролын арга зүйн сургалтад хамрагдсан бөгөөд **72 хувь** нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг үнэлэх, эрт илрүүлэх, ГСТ боловсруулж үнэлэх аргачлалыг сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг болсон байна.

Зорилтот сургуулиудын багш нарын тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн талаарх мэдлэг ойлголт, хандлага, тэднийг илрүүлэх, ГСТ-г хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх, тэдний эцэг эхтэй хамтран ажиллах мэдлэг, ур чадварт ахиц гарч, энэ талаарх сургуулийн чадавх сайжирсан байна.

Төслийн хүрээнд зорилтот сургуулиудад байгуулагдсан Хүүхэд хөгжлийн төвийг тусгай хэрэгцээт хүүхдийг сургах, хөгжүүлэх чиглэлээр хэрхэн ашиглаж байгааг авч үзвэл тусгай хэрэгцээт хүүхэдтэй 4-5 дугаар анги удирдсан багш нарын 90.2 хувь нь, тусгай хэрэгцээт хүүхэдтэй 6-9 дүгээр анги удирдсан багш нарын 81.8 хувь нь үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна.



Модуль 2 багш нарын сургалт,
79-р сургууль, 2023.09.30



Хүүхэд хөгжлийн төвийн хэрэглэгдэхүүнийг
ашиглах аргазүйн сургалт
ЯХИС Хүүхэд хөгжлийн арга зүйн төв, 2022.12.20

ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ТӨСӨЛ - 2

ТӨСӨЛД ХАМРАГДСАН **6-9 ДҮГЭЭР АНГИЙН** ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХЭД (ХҮЙСЭЭР), БАГШ, СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ТОО (СУРГУУЛЬ ТУС БҮРЭЭР)



Нийт сургуулийн тоо **15**



Нийт багшийн тоо **743**










Нийт тусгай хэрэгцээт хүүхдийн тоо **110**



Нийт сэтгэл зүйчийн тоо **14**

Сэтгэл зүйчтэй	Багш	Эрэгтэй хүүхэд	Эмэгтэй хүүхэд
Сэтгэл зүйчтэй БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 79-Р СУРГУУЛЬ	79	23	3
Сэтгэл зүйчтэй ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 37-Р СУРГУУЛЬ	51	22	8
Сэтгэл зүйчтэй СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 76-Р СУРГУУЛЬ	34	8	2
Сэтгэл зүйчтэй ХОВД, ЖАРГАЛАНТ 3-Р СУРГУУЛЬ	37	6	2
Сэтгэл зүйчтэй СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 67-Р СУРГУУЛЬ	56	6	2
Сэтгэл зүйчтэй БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 30-Р СУРГУУЛЬ	82	2	3
Сэтгэл зүйчтэй СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 9-Р СУРГУУЛЬ	74	1	4

 Сэтгэл зүйчтэй ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 39-Р СУРГУУЛЬ	Багш  51	Эрэгтэй хүүхэд  2	Эмэгтэй хүүхэд  3
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ АМГАЛАН ЦОГЦОЛБОР ДУНД СУРГУУЛЬ	Багш  44	Эрэгтэй хүүхэд  4	Эмэгтэй хүүхэд  1
 Сэтгэл зүйчтэй СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 65-Р СУРГУУЛЬ	Багш  27	Эрэгтэй хүүхэд  1	Эмэгтэй хүүхэд  4
 Сэтгэл зүйчтэй ХОВД, ЖАРГАЛАНТ 7-Р СУРГУУЛЬ	Багш  41	Эрэгтэй хүүхэд  2	Эмэгтэй хүүхэд  2
 Сэтгэл зүйчтэй ӨВӨРХАНГАЙ, АРВАЙХЭЭР 2-Р СУРГУУЛЬ*	Багш  43		Эмэгтэй хүүхэд  2
 Сэтгэл зүйчтэй ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 49-Р СУРГУУЛЬ	Багш  43		Эмэгтэй хүүхэд  2
 Сэтгэл зүйчтэй БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 127-Р СУРГУУЛЬ	Багш  29	Эрэгтэй хүүхэд  1	Эмэгтэй хүүхэд  1
 Сэтгэл зүйчтэй ӨВӨРХАНГАЙ, УЯНГА 1-Р СУРГУУЛЬ	Багш  16	Эрэгтэй хүүхэд  1	

*Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р сургуулийн тусгай бүлгийн сурагчдыг тусгай хэрэгцээтэй хүүхдэд тооцоогүй болно.

ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ТӨСӨЛ - 2

ТӨСӨЛД ХАМРАГДСАН **4-5 ДУГААР АНГИЙН** ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХЭД (ХҮЙСЭЭР), БАГШ, СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ТОО (СУРГУУЛЬ ТУС БҮРЭЭР)



Нийт сургуулийн тоо **15**



Нийт багшийн тоо **178**



Нийт тусгай хэрэгцээт хүүхдийн тоо **84**



Нийт сэтгэл зүйчийн тоо **14**

Сэтгэл зүйчтэй	Багш	Эрэгтэй хүүхэд	Эмэгтэй хүүхэд
Баянзүрх дүүрэг 79-р сургууль	13	12	8
Баянзүрх дүүрэг Амгалан Цогцолбор дунд сургууль	14	7	1
Ховд, Жаргалант 3-р сургууль	9	5	3
Сонгинохайрхан дүүрэг 9-р сургууль	17	5	2
Сонгинохайрхан дүүрэг 67-р сургууль	17	4	2
Сонгинохайрхан дүүрэг 65-р сургууль	10	5	1
Чингэлтэй дүүрэг 37-р сургууль	10	5	

 Сэтгэл зүйчтэй ХОВД, ЖАРГАЛАНТ 7-Р СУРГУУЛЬ	Багш  6	Эрэгтэй хүүхэд  4	Эмэгтэй хүүхэд  1
 Сэтгэл зүйчтэй БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 30-Р СУРГУУЛЬ	Багш  15	Эрэгтэй хүүхэд  2	Эмэгтэй хүүхэд  2
 Сэтгэл зүйчтэй БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 127-Р СУРГУУЛЬ	Багш  12	Эрэгтэй хүүхэд  3	Эмэгтэй хүүхэд  1
 Сэтгэл зүйчтэй ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 49-Р СУРГУУЛЬ	Багш  8	Эрэгтэй хүүхэд  1	Эмэгтэй хүүхэд  3
 Сэтгэл зүйчтэй ӨВӨРХАНГАЙ, АРВАЙХЭЭР 2-Р СУРГУУЛЬ*	Багш  14	Эрэгтэй хүүхэд  3	
 Сэтгэл зүйчтэй ӨВӨРХАНГАЙ, УЯНГА 1-Р СУРГУУЛЬ	Багш  5	Эрэгтэй хүүхэд  1	Эмэгтэй хүүхэд  1
 Сэтгэл зүйчтэй ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 39-Р СУРГУУЛЬ	Багш  11	Эрэгтэй хүүхэд  1	
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 61-Р СУРГУУЛЬ	Багш  3	Эрэгтэй хүүхэд  1	

*Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р сургуулийн тусгай бүлгийн сурагчдыг тусгай хэрэгцээтэй хүүхдэд тооцоогүй болно.

ТӨСӨЛД ХАМРАГДСАН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДИЙН ТОО, ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ТӨРЛӨӨР



*БЗД-ийн 79 болон Ховд аймгийн 3-р сургуулиас бусад сургуулийн хувьд албан ёсны оноштой хүүхдийг тусгай хэрэгцээт хүүхэд гэж авч үзсэн болно.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЗОРИЛТОТ 16 СУРГУУЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН ТОО



4-5 дугаар
ангийн багш

193



6-9 дүгээр
ангийн багш

739



Сургуулийн
удирдах ажилтан

48



Нийгмийн
ажилтан

16



Сэтгэл зүйч

15



4-5 дугаар ангийн сурагч

6,823

(Үүнээс, тусгай хэрэгцээт
84 сурагч)



Эцэг эх

1,624

НИЙТ 21.191

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсрол, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг гэрийн орчинд дэмжих талаарх ойлголтоо нэмэгдүүлсэн байна.



Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эхчүүд бүгд (100 хувь) хүүхдийнхээ сурч хөгжихөд дэмжлэг болох сургалтын орчин бүрдүүлэх, тэдний хөгжил, суралцах үйл явцад нь тусалж анхаардаг болсон гэж хариулжээ.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад эцэг эхчүүд хүүхэдтэй нь хамт суралцдаг тусгай хэрэгцээтэй хүүхдэд хандах хандлага, ойлголт эергээр өөрчлөгдсөн байна. Тэгш хамруулах боловсролын чиглэлээрх сургалтад бага, дунд ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн хоёр хүн тутмын

нэг нь хамрагдсан байна. Сургалтад хамрагдсан бага ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн дийлэнх олонх нь (86.4 хувь), 6-9 дүгээр ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн ихэнх нь (75 хувь) нь хүүхдүүдтэйгээ тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголтоо хуваалцсан байна.



Эцэг эхийн сургалтад 4-9 дүгээр ангийн 103 эцэг эх хамрагдаж байна.
76-р сургууль, 2023.10.30



"Тэгш хамруулах боловсрол" олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлын үеэр эцэг эхчүүд мэдээлэл, зөвлөгөө авч байна.
37-р сургууль, 2023.02.22

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4.

Суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролыг дэмжих бодлого, журмыг боловсронгуй болгох, тэгш хамруулах боловсролын тогтолцоог бүрдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна.



Боловсролын салбарт хамаарах **бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд** тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд суралцах, тэдэнд нийгмийн суурь үйлчилгээг үзүүлэх асуудлуудыг тусгаж эрх зүйн хүрээнд баталгаажуулсан бөгөөд улсын төсвөөс үүнд зарцуулах төсөв нэмэгдсэн байна.



Судалгаанд оролцсон багш нарын **88 хувь** нь сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайн, үр дүнтэй ажиллаж байна гэж дүгнэсэн байна. Дэмжлэгийн багийн зохион байгуулсан сургалтууд мэдээлэл сайтай, хүртээмжтэй зохион байгуулагдаж чадаж байгаа гэж багш нар үзэж байна



“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь – 2” төсөл нь суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролын тогтолцоог бий болгох хүрээнд хууль эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, бодлогын нөлөөллийн төрөл бүрийн үйл ажиллагааг цогц байдлаар хэрэгжүүлсэн нь гол ялгарах онцлог болжээ.

Төсөл хэрэгжсэнээр зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамруулах үйл ажиллагаанд гарсан үр дүнг багш нар хэрхэн дүгнэж байгааг авч үзвэл 1. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарын мэдлэг, ур чадвар, хандлага өөрчлөгдсөн. 2. Тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах боломж нөхцөл нэмэгдсэн 3. Сургалтын орчин сайжирсан 4. Багш, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирсан гэж үзжээ.



Боловсролд тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэх менежментийн асуудлууд” сургалтад сургуулийн удирдлагууд оролцож байна.

Монгол Япон төвийн сургалтын танхим, 2023.10.27



Тэгш хамруулан сургах Боловсролын зөвлөлийн хурал, 2024.01.18



ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотын гурван дүүрэг, Өвөрхангай болон Ховд аймгийн зорилтот сургуулиудын бага, дунд ангийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

✓ ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

- 1 Зорилтот сургуулийн 5-р ангийн сурагчдыг дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх;
- 2 Суурь боловсролын түвшинд тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох;
- 3 Зорилтот сургуулийн эцэг эхчүүдэд хүүхдийнхээ анги дэвших болон цаашид суралцах үйл явцад туслахад дэмжлэг үзүүлэх;
- 4 Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, тэгш хамруулан сургах боловсролын төрийн бодлогод тусгах

₮ ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Япон улсын Гадаад Хэргийн Яам

🕒 ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

3 жил (2021 оны 3 сар - 2024 оны 3-р сар)

👤 ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД:

Шууд: 20,606 **Шууд бус:** 28,650

🏠 ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БҮЙ ЕБС-ИУД

Баянзүрх дүүргийн 79, 127, 30-р сургууль,
Амгалан цогцолбор сургууль
Чингэлтэй дүүргийн 37, 49, 39, 61-р сургууль
Сонгинохайрхан дүүргийн 67, 65, 9, 76-р сургууль
Өвөрхангай аймгийн 2-р сургууль, Уянга сумын 1-р сургууль
Ховд аймгийн 7, 3-р сургууль



Save the Children

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361

✉ secretary@savethechildren.mn
🌐 mongolia.secretary@savethechildren.org
📱 Save the Children in Mongolia
🇺🇸 Save the Children MN